



**ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2025 оны 11 сарын 06 өдөр

Дугаар 4/237

Улаанбаатар хот

**Гамшгаас хамгаалах мэргэжлийн анги
байгуулах тухай**

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсэг, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.3 дахь заалт, 51 дүгээр зүйлийн 51.2 дахь хэсэг, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, 17.2.4 дэх заалт, Монгол Улсын Шадар сайдын 2017 оны 75 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь :

1. Тус газрын хэвийн үйл ажиллагааг хангах, аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх, хамгаалах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, ажлын хувцас, багаж хэрэгслийн жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд сургаж дадлагажуулах, бэлтгэл бэлэн байдлыг хангах, мэргэжлийн ангид хөтлөгдөх баримт бичгүүдийг тухай бүр шинэчилж байхыг гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн дарга (Захиргааны хэлтсийн дарга)-д даалгасугай.
3. Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлыг төлөвлөх, зориулалтын дагуу зарцуулах, мэргэжлийн ангид шаардлагатай хөрөнгийг шийдвэрлэж, ажиллах нөхцөлөөр хангахыг Санхүү, аж ахуйн хангалтын дарга (Ерөнхий нягтлан бодогч)-д үүрэг болгосугай.

ДАРГА




Э.БАТТУЛГА

15125075

d:\2025\а тушаал\11.06-237.docx

Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын
2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн
А/237 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



Цаг уур, орчны шинжилгээний газрын
гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн

№	Албан тушаал		Овог нэр
	Томилгоожсон	Үндсэн	
1	Мэргэжлийн ангийн дарга	Захиргааны хэлтсийн дарга	
2	Орлогч бөгөөд сургалт, сурталчилгаа хариуцсан ажилтан	Мэдээллийн студи хариуцсан ерөнхий инженер	
3	Хэв журам, аюулгүй байдал бүлэг	Улсын сүлжээний газрын дарга	
4	Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан ажилтан	Цахим сүлжээ, кибер аюулгүй байдал хариуцсан ахлах мэргэжилтэн	
5	Анхны тусламжийн бүлгийн дарга	Урьдчилан мэдээлэх газрын дарга	
6	Хангалт хариуцсан бүлгийн дарга	Ерөнхий нягтлан бодогч	
7	Гал унтраах бүлгийн дарга	Захиргааны хэлтсийн дарга	
8	Нүүлгэн шилжүүлэх бүлгийн дарга	Архив, мэдээллийн сангийн хэлтсийн дарга Технологи, инновацийн хэлтсийн дарга	
9	Шуурхай бүлгийн дарга	Хяналт дотоод аудитын хэлтсийн дарга	
10	Аврах бүлэг	Уур амьсгалын өөрчлөлт, орчны шинжилгээний хэлтсийн дарга	

---ooOoo---

Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын
2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн
А/237 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

№	Ажлын хувцас, багаж хэрэгслийн нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг
1	Нүдний хамгаалах хэрэгсэл	ширхэг	7
2	Малгай, каск	Ширхэг	5
3	Ажлын хувцас /өвөл, зуны/	Хос	70
4	Ажлын гутал	хос	5
5	Бээлий	хос	10
6	Цув	ширхэг	5
7	Гар чийдэн	ширхэг	7
8	Мяндсан олс	метр	100
9	Бэхэлгээний бүс	ширхэг	7
10	Хүрз	ширхэг	7
11	4 хүний майхан	ширхэг	2
12	Аяны хөнжил	ширхэг	5
13	Эмийн сан, анхны тусламжийн иж бүрдэл	хайрцаг	1
14	Галын хор	ширхэг	20ш

Эмнэлгийн анхны тусламжийн иж бүрдэл

№	Бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Тайлбар
1	Спиртийн уусмал	50 мл	1	
2	Иодын уусмал	50 мл	1	
3	Эмнэлгийн хөвөн	Боодол /50гр/	5	
4	Эмнэлгийн бинт	Ширхэг/14см*7см/	10	
5	Уян боолт	Ширхэг/10см*4,5м/	10	
6	Цаасан лент	Ширхэг/5см*7,5м/	1	
7	Хуруу лент	Ширхэг	100	
8	Эмнэлгийн бээлий	Ширхэг	100	
9	Амны хаалт	Ширхэг	100	
10	Иж бүрдлийн хайрцаг	Ширхэг	1	
11	Хогийн уут	Боодол	5	
12	Анальгин	Боодол	2	
13	Парацетомол	Боодол	2	

-----ooOoo-----